



ЗАВХАН АЙМГИЙН ТЭЛМЭН
СУМЫН СОНГУУЛИЙН ХОРООНД

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улаастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2024.08.28

№

446

танай _____ -ны № _____ -т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр
хуульд заасан шаардлагад
нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох Мөнхтөрийн Түвдэнсүрэнгийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл


Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Мөнхтөрийн Түвдэнсүрэнгийн /РД:ИН96070910/ Орон нутгийн Хурлын сонгуульд оролцооор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

М.Түвдэнсүрэнгийн мөрийн хөтөлбөр (1 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Бие даан нэр дэвшигч М.Түвдэнсүрэнд



Завхан аймаг Тэлмэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын
төлөөлөгчид бие даан нэр дэвшигч
МӨНХТӨРИЙН ТҮВДЭНСҮРЭН-ийн мэрийн хөтөлбөр

1. Малын тоо толгой бус үүлдэрлэг байдлыг сайжруулах бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
2. Сумын иргэдийг эмнэлгийн иж бүрэн оношилгоо үйлчилгээнд хамруулах бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
3. Нийтийн биесийн тамирыг хөгжүүлэх, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг оношлогоонд хамруулах талаар сумын холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.
4. Төр засгийн бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын болон дээд шатны хурал, Засаг даргын шийдвэрийн сурталчлан хэрэгжүүлж ажиллана.
5. Иргэдээс гарсан санал хүсэлтийг цаг тухай бүр эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжилж шийдвэрлүүлнэ.
6. Эмзэг бүлгийн иргэдийг халамжийн үйлчилгээнд бүрэн хамруулах бодлого баримтална.
7. “Шинэ хоршоо” хөдөлгөөнийг дэмжиж, орон нутагт малын гаралтай түүхий эд боловсруулах бага оврын тоног төхөөрөмжийн цех ажиллуулан анхан шатны боловсруулалт хийж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.
8. Сум орон нутагтаа аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогыг дэмжиж ажиллана
9. Иргэдийг аливаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах бодлогыг боловсруулан хэрэгжүүлнэ.
10. “Тэрбум мод”- Үндэсний хөдөлгөөний хүрээнд цөлжилтийг бууруулах мод бут сөөг тариалах ажлыг эрчимжүүлэн үе шаттайгаар зохион байгуулна.

Мэрийн хөтөлбөр боловсруулсан:

Тэлмэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчид бие даан нэр
дэвшигч: Мөнхтөрийн Түвдэнсүрэн/*Түвдэнсүрэн* /